

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна” гэж заасан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын төсөвт 2024 оны төвлөрүүлэх орлого, зарлагын бүрэлдэхүүнд Засгийн газрын тохируулагч агентлаг “Иргэний нисэхийн ерөнхий газар” байгуулах асуудал тусгагдаагүй болно.

Үүнтэй уялдуудан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэлд “Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан” болно.

Иймд Иргэний нисэхийн тухай хуульд хуульчилсан Засгийн газрын тохируулагч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газар нь 2024 онд байгуулагдахгүй болсон тул Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн болно.

Хуулийн төслийн зорилго нь Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагаж мөрдөх хугацааг өөрчлөхтэй холбоотой болно.

Хуулийн төсөл нь Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үйлчлэх хугацааг өөрчлөх 1 заалттай бөгөөд шинээр нэр томьёо тусгагдаж болно.

Иргэний нисэхийн тухай хуулийг 1999 оноос өнөөг хүртэл мөрдөж байгаа болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн хуулийн төслийн үзэл баримтлалын хамт боловсруулан, төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авч, Засгийн хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Иргэний нисэхийн тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх нөхцөл бүрдэх бөгөөд улмаар улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал шийдвэрлэгдэх юм.

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР